



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРОО**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2015. 01. 22 № 7 / 556

танай _____ -ны № _____ -т

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай

Тус Байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Дорноговь, Баянхонгор аймгийн иргэдээс Байгаль орчныг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийг шалгаж Байнгын хорооны 2014 оны 09 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газарт хуулийн хэрэгжилтийг хангах чиглэл өгч шийдвэрлэсэн.

Газрын тухай хуулийн 20.1.3-т зааснаар газрыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох бүрэн эрхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлэхээр заасан боловч улсын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан шийдвэр нь зөрчилтэй гэх 1738 газар байгаагаас тусгай хэрэгцээнд авах зорилго тодорхойгүй 374, шийдвэр гаргах эрхгүй байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргасан 545, тусгай хамгаалалтад авах хугацаа заагаагүй зөрчилтэй 819 шийдвэр байна.

Тусгай хэрэгцээнд авсан газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл давхардуулан олгох, иргэд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс газрыг тусгай хэрэгцээнд авах тухай шийдвэрүүдийг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд Ашигт малтмалын газарт бүртгүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж, тус Байнгын хороонд эргэн мэдэгдэнэ үү.

Жич: Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахдаа хэт хязгаарлагдмал хэмжээтэй тогтоож байгаа нь шаардлага хангахгүй байна.

Холбогдох материалыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О. БААСАНХҮҮ



0000000264